



МОНГОЛ УЛС  
ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

9093 оны 05 сарын 02 өдөр

Дугаар A/269

Мандалговь

Эх, хүүхэд, нөхөн үржихүйн эрүүл  
мэндийн орон тооны бус  
салбар зөвлөл байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 66 дугаар зүйлийн 66.1, Эрүүл мэндийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.1, 11.1.2, Засгийн газрын 2020 оны 203 дугаар тогтоолоор батлагдсан "Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө"-ний 2.1.1-ийн 3 дахь заалт, Эрүүл мэндийн сайдын 2022 оны 12 дугаар сарын 09-ний А/590, 2021 оны А/760 дугаар тушаалыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. "Эх, хүүхэд, нөхөн үржихүйн эрүүл мэндийн орон тооны бус салбар зөвлөл"-ийн бүрэлдэхүүнийг нэгдүгээр, тус салбар зөвлөлийн чиг үүргийг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Эх, хүүхэд, нөхөн үржихүйн бодлогыг хэрэгжүүлэхэд салбар дундын хамтын ажиллагааг өргөжүүлэн, салбар зөвлөлийг мэргэжлийн удирдлага арга зүйгээр ханган ажиллахыг "Эх, хүүхэд, нөхөн үржихүйн эрүүл мэндийн орон тооны бус салбар зөвлөл"-ийн орлогч дарга (Б.Алтантөгс)-д үүрэг болгосугай.

3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Нийгмийн бодлогын хэлтэс (Н.Эрдэнэ-Очир)-т даалгасугай.

ЗАСАГ ДАРГА

Ц.МОНХБАТ

4823100716

Аймгийн Засаг даргын 2023 оны 05 дугаар  
сарын 09-ны өдрийн 05 дугаар захирамжийн  
нэгдүгээр хавсралт

ЭХ, ХҮҮХЭД, НӨХӨН ҮРЖИХҮЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ОРОН ТООНЫ БУС  
САЛБАР ЗӨВЛӨЛИЙН БҮРЭЛДЭХҮҮН

Салбар зөвлөлийн дарга  
Салбар зөвлөлийн орлогч дарга  
Салбар зөвлөлийн нарийн бичгийн дарга

Аймгийн Засаг дарга  
Эрүүл мэндийн газрын дарга  
Эрүүл мэндийн газрын Эх барих  
эмэгтэйчүүдийн тусlamж үйлчилгээ  
хариуцсан мэргэжилтэн

Салбар зөвлөлийн гишүүд:

Нийгмийн бодлогын хэлтсийн дарга  
Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга  
Боловсрол, шинжлэх ухааны газрын дарга  
Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын дарга  
Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын дарга  
Улсын бүртгэлийн хэлтсийн дарга  
Статистикийн хэлтсийн дарга  
Эрүүл мэндийн даатгалын хэлтсийн дарга  
Эрүүл мэндийн газрын Эмнэлгийн тусlamжийн  
хэлтсийн дарга  
Эрүүл мэндийн газрын Нийгмийн эрүүл мэндийн  
хэлтсийн дарга  
Эрүүл мэндийн даатгалын хэлтсийн дарга  
Нэгдсэн эмнэлгийн дарга  
Нэгдсэн эмнэлгийн Хүүхдийн ерөнхий мэргэжилтэн  
Нэгдсэн эмнэлгийн Эх барих, эмэгтэйчүүдийн  
еरөнхий мэргэжилтэн  
Засаг даргын Тамгын газрын хэвлэлийн ажилтан  
Төрийн бус байгууллагын төлөөлөл (зөвшилцсөнөөр)

Аймгийн Засаг даргын 2023 оны 05 дугаар  
сарын 05 -ны өдрийн 05 дугаар захирамжийн  
хоёрдугаар хавсралт

ЭХ, ХҮҮХЭД, НӨХӨН ҮРЖИХҮЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ОРОН ТООНЫ БУС  
САЛБАР ЗӨВЛӨЛИЙН ЧИГ ҮҮРЭГ

1. Аймгийн хэмжээнд “Эх, хүүхэд, нөхөн үржихүйн эрүүл мэнд” арга хэмжээний /2021-2024 он/ төлөвлөгөөний бодлогын хэрэгжилтийг хангах;
2. Аймгийн эх, хүүхэд, нөхөн үржихүйн эрүүл мэндийн орон тооны бус салбар зөвлөлийн үйл ажиллагааны үндсэн хэлбэр нь хуралдаан байна. Хуралдааныг шаардлагатай тохиолдол бүрд зарлан хуралдуулах;
3. Орон тооны бус салбар зөвлөлийн хуралдаанаар хэлэлцэн шийдвэрлэсэн асуудлаар захирамж, хурлын тэмдэглэл гарна. Хэлэлцсэн асуудлаарх холбогдох шийдвэрийг харьяа байгууллагуудад хүргүүлж, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллах;
4. Эх, хүүхэд, өсвөр үе, нөхөн үржихүйн эрүүл мэндийн чиглэлээр үйл ажиллагаа эрхэлж буй төрийн болон төрийн бус байгууллагуудын үйл ажиллагааг уялдуулан, мэргэжил арга зүйн зөвлөгөө өгөх;
5. Эх, хүүхэд, өсвөр үе, нөхөн үржихүйн эрүүл мэндэд зарцуулах санхүүжилт, хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэхэд ухуулга нөлөөллийн ажил зохион байгуулах;
6. Эх, хүүхэд, өсвөр үе, нөхөн үржихүйн эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чиглэлээрх бодлогын баримт, бичиг, тушаал, заавар, зөвлөмж, журам, стандартын хэрэгжилтийг хангаж ажиллах;
7. Өөрийн нутаг дэвсгэр дээр эх, хүүхэд, өсвөр үе, нөхөн үржихүйн эрүүл мэндийн чиглэлээр хэрэгжиж буй төсөл болон арга хэмжээний төлөвлөгөөнүүдийн хэрэгжилтийг нэгдсэн удирдлагаар хангаж, бусад төсөл болон арга хэмжээний төлөвлөгөөтэй уялдуулах;
8. Аймгийн түвшинд эх, хүүхэд, өсвөр үе, нөхөн үржихүйн эрүүл мэндийн чиглэлээр үнэлгээ хийж, үр дүнг тооцон хэлэлцэх;
9. “Эх, хүүхэд, нөхөн үржихүйн эрүүл мэнд” арга хэмжээний /2021-2024 он/ төлөвлөгөө болон түүнийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд хийгдэж буй төсөл, арга хэмжээнүүдэд хяналт тавьж, дүн шинжилгээ хийх;
10. “Эх, хүүхэд, нөхөн үржихүйн эрүүл мэнд” арга хэмжээний үр дүнгийн тайланг тогтоосон хугацаанд холбогдох байгууллагуудад хүргүүлэх;